*АГУУЛГА*

***НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .......... 2***

*1.1 Төслийн ерөнхий мэдээлэл .......... 2*

*1.2 Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил: .......... 2*

*1.3 Уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа, ажиллах горим .......... 3*

*1.4 Уурхайн нээлт, ашиглалт явуулах дараалал .......... 4*

*1.5 Уурхайн үндсэн үйл ажиллагаанууд, тоног төхөөрөмж .......... 5*

*1.6 Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим .......... 5*

*1.7 Баяжуулах үйлдвэр .......... 6*

*1.8 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө .......... 7*

***ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ .......... 9***

***ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗАРДАЛ .......... 21***

***ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .......... 21***

***ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .......... 21***

***ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .......... 21***

***ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .......... 21***

***НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .......... 26***

***ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .......... 34***

# НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### *1.1 Төслийн ерөнхий мэдээлэл*

| № | Үндсэн үзүүлэлтүүд | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Төсөл хэрэгжүүлэгч байгууллага | “ШИДЭТ-ОД” ХХК |
| 2 | Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг | Улаанбатар хот, Баянзүрх дүүрэг,<br>2-р хороо, Дарь-Эхийн 12-392 тоот<br>Утас: (976)-9404-7484 |
| 3 | Хүчинтэй хууль эрхзүйн баримт бичгүүдийн жагсаалт | 1. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ:<br>Улсын бүртгэлийн дугаар: 9011064033<br>Улсын регистрийн дугаар: 2884259<br>Улсад бүртгүүлсэн: 2005.12.28<br>2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл:<br>Дугаар: MV-009631<br>Олгосон огноо: 2007.08.09 |
| 4 | Ордын геологийн нөөц | Хайлуур жоншны хүдэр: 315.1 мян.тн |
| 5 | Ордын үйлдвэрлэлийн нөөц | Хайлуур жоншны хүдэр: 132.7 мян.тн |
| 6 | Уурхайн жилийн хүчин чадал | Хайлуур жоншны хүдэр: 30.00 мян.тн<br>Хөрс хуулалт: дундажаар 46.0 мян.$м^3$<br>ФК-75 маркийн бүхэллэг жонш үйлдвэрлэл: 9.0 мян.тн<br>Хөрс хуулалтын коэффициент: 1.72 $м^3$/ тн |
| 7 | Ордын ашиглалтын хугацаа | 5 жил |
| 8 | Ус хангамж | Дорноговь аймгийн Өргөн сумын төвийн худгаар хангана.<br>Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах усны хэрэгцээ: 23.68 $м^3$/хон |
| 9 | Цахилгаан хангамж | Өмнөд бүсийн өндөр хүчдэлийн шугамаас 1 км зайтай тус 35 кВА шугам татахаар төлөвлөсөн. |
| **10** | **Нийт хөрөнгө оруулалт** | **1674.4 сая.төг** |

### *1.2 Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:*

“Баргилт овоо” нэртэй хайлуур жоншны ордын 6-р хүдрийн биетийг (1, 2, 2а, 3-р биет) ил уурхайн аргаар ашиглах төсөл нь Улаанбаатар хотоос зүүн урагш 535 км, Сайншанд хотоос зүүн урагш 60 км, Өргөн сумын төвөөс баруун урагш 4.8 км-т 20.29 га талбайг эзлэн дараахсолбилцолд оршино. Төсөл хэрэгжих талбайн солбицлыг доорх хүснэгтэнд үзүүлэв.




*Зураг 1. Төсөл хэрэгжих газрын топо зураг*

### *1.3 Уурхайн хүчин чадал, ашиглалтын хугацаа, ажиллах горим*

*Уурхайн хүчин чадал*

“Шидэт-Од” ХХК-ийн техникийн даалгаврын дагуу уурхайн хүчин чадал жилд ил аргаар 30.0 мян тн хүдэр олборлон борлуулахаар техник эдийн засгийн үндэслэлд тусгав.

*Уурхайн ашиглалтын хугацаа*

Сонгон авсан уурхайн хил хязгаар доторх үйлдвэрлэлийн магадлагдсан ил уурхайн хүдрийн нөөц 132.7 мян. тонн, үүнийг захиалагчийн техникийн даалгаврын дагуу ил аргаар олборлох нөөцийг жилд 30.0 мян тн-оор олборлоход:

$$T=\frac{132.7 \text{мян тн}}{30.0 \text{ мян тн}}=4.4 \text{ жилд буюу 5 жилд ашиглана.}$$

*Уурхайн ажиллах горим*

Баргилт овоо жоншны ил уурхай дулааны улиралд буюу 4 сарын 1-нээс 11 сарын 1-ний хооронд 7 сарын хугацаанд ажиллана. Ажилчдын баяр ёслолын үеийн болон амралтын үеийн амрах хугацааг МУ-ын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу уурхайн даргын тушаалаар зохицуулна.

Уурхайн олборлолтын үйл ажиллагаа нь хоногт 10 цагийн 1 ээлжээр ажиллах горимыг барина. Ингэснээр уг уурхай нь жилдээ 167 хоног буюу 1670 цаг ажиллах юм.

### *1.4 Уурхайн нээлт, ашиглалт явуулах дараалал*

Эхний ээлжинд 2007-2010 оны үед ухсан уурхайн ухашыг жигдрүүлэх буюу хамгийн сүүлд 2018 онд хийсэн маркшейдерийн хэмжилтийн тайлангаас харахад хуучин ухашын ёроолын түвшин +1015-+1020м-ийн түвшинд байна. Иймд уурхайн зүүн хойд талын бортыг өргөсгөж, +1020м, +1015м-ийн түвшин хүртэлх хөрс хуулалтын ажлыг хийж, B’I-2 хүдрийн блок, B’ II-3, B’ IIa-5 блокуудын дээд хэсгийн хүдрийг ил уурхайн аргаар эхний жилд олборлоно. Дараагийн жилүүдэд B’ I-1, B’I-2, B’ II-3, B’ II-4, B’ II-5 блокуудыг доод талын түвшингүүдэд олборлох юм. Үүнийг уулын ажлын календарь төлөвлөгөөнд түвшин бүрээр тодорхой үзүүллээ.

Олборлолтын ажлын өмнө ил уурхайн ажлаар эвдрэлд орох талбайн шимт хөрсийг дунджаар 0.15 м зузаантайгаар хуулж тусгайлан овоолгод хураана. Шимт хөрсний овоолгыг уурхайн ашиглалтын эцэст эвдрэлд өртсөн талбайг нөхөн сэргээж, ургамалжуулах ажилд хэрэглэнэ. Мөн олборлолтын явцад гарах хоосон чулуулгийг ил уурхайгаас тээвэрлэн хөрсний овоолгод хураана. Шимт хөрсийг хуулах болон овоолгын ажилд бульдозер ажиллана.

Ил уурхайгаар 1-5 дахь жилийн уулын ажлыг бүрэн хийж гүйцэтгэнэ. Ил уурхайн ажлын хэмжээ, хүдэр олборлолт, шимт хөрс хуулах ажлын хэмжээг дараах 9, 10-р хүснэгтүүдэд үзүүллээ

*Хүснэгт 1.Ил уурхайн уулын ажлын хэмжээ*

| Үзүүлэлт | Нэгж | Хэмжээ |
|---|---|---|
| Хүдэр олборлолт | $м^3$ | 49066 |
| Хүдрийн эзлэхүүн жин | $тн/м^3$ | 2.67 |
| Хүдэр олборлолт | тн | 132741.6 |
| Хөрс хуулалт | $м^3$ | 228094 |
| Уулын цул | $м^3$ | 277160 |
| Хөрс хуулалтын коэффициент | $м^3/тн$ | 1.72 |

*Хүснэгт 2.Шимт хөрс хуулах ажлын хэмжээ*

| Үзүүлэлт | Нэгж | үзүүлэлт |
|---|---|---|
| Ил уурхайн талбай | га | 1.36 |
| Хөрсний овоолгын талбай | га | 1.19 |
| Уурхайн зам | га | 0.4 |
| Ангилан ялгасан жоншны овоолго | Га | 0.025 |
| Жоншны хүдэр ангилан ялгах талбай | га | 0.01 |
| Уурхайн захиргаа, ажилчдын тосгоны талбай | га | 0.116 |
| Шимт хөрс хуулах нийт талбай | га | 3.411 |
| Шимт хөрс хуулах зузаан | м | 0.15 |
| Шимт хөрс хуулах ажлын хэмжээ | $м^3$ | 51116.5 |

### *1.5 Уурхайн үндсэн үйл ажиллагаанууд, тоног төхөөрөмж*

*Хөрс хуулалт, овоолго болон агуулах*

Төслөөр хөрсний овоолгыг уурхайн зүүн урд талд байршуулахаар төлөвлөсөн болно. Уурхайн ашиглалтын төгсгөлд хөрсний овоолго нь 20 м өндөртэй, нийтдээ 2.6 га талбайг эзлэн байршихаар байна.

Шимт хөрсний овоолгыг уурхайн талбайн баруун хойт хүрээг дагуулан уурхайгаас 10 метрийн зайтай зурвас үүсгэн байршуулж хадгална. Шимт хөрсний овоолгын өндөр нь 3 метр, өргөн нь 10 метр байна.

Уурхайн ашиглалтын хугацаанд нийт хуулагдах хөрсний хэмжээ 226.7 мян.м$^3$, шимт хөрсний хэмжээ 6.4 мян.м$^3$ байна.

Овоолгыг зурагт заасан хэмжээгээр хэлбэржүүлэх, зам засаж тэгшлэх ажлыг Shantui маркийн бульдозероор ээлжийн туршид гүйцэтгэнэ. Өөрөө буулгагч автосамосвалаар тээвэрлэн овоолгод хүргэсэн чулуулгийг овоолгын нурлын бүсээс дотогш буюу хамгаалалтын шороон далангаас 1.0-1.5 м-ийн зайд буулгана.

Овоолгын тэгшлэн зассан талбайн төвөөс овоолгын ирмэг талруу 3°-аас багагүй налуутай байна.

*Хүснэгт 3. Ил уурхайд ашиглах тоног төхөөрөмж*

| № | Тоног төхөөрөмжийн нэр | Марк | Тоо хэмжээ ш |
|---|---|---|---|
| 1 | Өрмийн машин | KY-125 | 3 |
| 2 | Гидро экскаватор (БНСУ) | R290LC-7 | 1 |
| 3 | Шууд утгуурт дугуйт ачигч (БНХАУ) | XCG-220L7A | 1 |
| 4 | Автосамосвал (БНХАУ) | ZZ3251 | 7 |
| 5 | Бульдозер | ShantuiSD | 1 |
| 6 | Бага оврын микроавтобус (БНСУ) | Hyundai | 1 |
| 7 | Шатахууны машин (БНСУ) | Hyundai | 1 |
| 8 | Усны машин | Hyundai | 1 |

### *1.6 Үйлдвэрийн хүчин чадал, ажиллах горим*

*Үйлдвэрийн хүчин чадал*

“Шидэт-Од” ХХК-ийн техникийн даалгаврын дагуу уурхайн хүчин чадал жилд ил аргаар 30.0 мян тн хүдэр олборлон борлуулахаар техник эдийн засгийн үндэслэлд тусгав.

*Хүснэгт 4. үйлдвэрлэлийн хүчин чадал төлөвлөлт*

| № | Ажлын горим | Хэмжих нэгж | Хугацаа |
|---|---|---|---|
| 1 | Ажил эхлэх хугацаа | сар, өдөр | 4 сарын 01 |
| 2 | Ажил дуусах хугацаа | сар , өдөр | 11 сарын 01 |
| 3 | Календарийн хоног | хоног | 214 |
| 4 | Баяр ёслолын болон амралтын өдөр | өдөр | 30 |
| 5 | Засвар үйлчилгээ (төлөвлөгөөт) | өдөр | 10 |
| 6 | Цаг агаарын саатал | өдөр | 7 |
| 7 | Жинхэнэ ажиллах боломжит өдөр | өдөр | 167 |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | Хоногийн ээлжийн тоо | ээлж | 1 |
| 9 | Ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 10 |
| 10 | Жилд ажиллах боломжит цаг | цаг | 1670 |

*Үйлдвэрийн ажиллах горим*

“Шидэт-Од” ХХК-ийн харьяа Баргилт овоо хайлуур жоншны ордын газрын гадаргад ойр буюу +1000м-ийн түвшнээс дээш орших хүдрийг ил аргаар олборлохоор захиалагчийн талаас шийдэл гаргасан тул дараах ажлууд хийгдэнэ. Үүнд:

- ✓ Олборлолтод өртөх ил уурхай, овоолго, зам, гар ялгалтын талбайд өртөх шимт хөрсийг хуулж тусгайд нь овоолох
- ✓ Батлагдсан хүдрийн нөөцийн гадна талаас ордыг нээх траншей бэлтгэх
- ✓ Өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар агуулагч чулуулаг болон хүдрийг сийрэгжүүлэх
- ✓ Экскаватораар хөрс хуулж, хүдэр олборлох
- ✓ Хуулсан хөрс, олборлосон хүдрийг өөрөө буулгагч авто машинд ачих
- ✓ Хуулсан хөрсний гадаад овоолгыг урьдчилан бэлдсэн талбайд байгуулах
- ✓ Олборлосон хүдрийг гар ялгалтын талбайд буулган ФК-75-аас дээш маркийн хүдрийг ангилан соортлох
- ✓ Ангилан ялгалтаас гарсан бага агуулгатай хүдрийн овоолго үүсгэхТоосго үйлдвэрлэх технологи

### *1.7 Баяжуулах үйлдвэр*

Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт орших “Өргөний 6-р хүдрийн бүс” -ийн олордын жоншны хүдэр ялган-ангилах үйлдвэр” технологийг ашиглан хагас үйлдвэрлэлийн туршилтыг явуулав.




***Зураг 2 “Өргөний 6-р хүдрийн биет” –ий ордын жоншны хүдэр ялган- ангилах үйлдвэрийн технологийн схем***

*Гар аргаар ангилан ялгах*

“Баргилт овоо” хайлуур жоншны ордын хүдрийн үйлдвэрлэлийн нөөц дэх 39.39 % агуулгатай хүдрийг ангилан ялгах төхөөрөмжийн дэргэд байгуулсан, тусгай бэлтгэсэн талбайд овоолсны дараа эхний ээлжинд гараар ялган бүхэллэг жоншыг ангилна.




***Зураг 3. Ордын ерөнхий технологийн схем***

### 1.8 Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

Ил уулын ажил явуулах ерөнхий уулын ажлын өрнөлтийг календарь төлөвлөгөөнд эхний жил 64666 м$^3$ хөрс хуулж, 12742 тн жонш олборлохоор төлөвлөсөн билээ (Хүснэгт 5.). 70000м$^3$ хөрс хуулалт, 2000тн жонш олборлосон байна.

*Хүснэгт 5. Уулын ажлын календарь төлөвлөгөө*

| д/д | Түвшин | 1 дэх жил | | 2 дахь жил | | 3 дахь жил | | 4 дэх жил | | 5 дахь жил | | нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хөрс | Хүдэр | Хөрс | Хүдэр | Хөрс | Хүдэр | Хөрс | Хүдэр | Хөрс | Хүдэр | Хөрс | Хүдэр |
| | | $м^3$ | тн | $м^3$ | тн | $м^3$ | тн | $м^3$ | тн | $м^3$ | тн | $м^3$ | тн |
| 1 | 1025 | 64666 | | 0 | | | | | | | | 64666 | |
| | 1020 | | 12742 | | 9870 | | | | | | | | 22612 |
| 2 | 1020 | | | 68774 | | | 8532 | | | | | 68774 | |
| | 1015 | | | | 20130 | | 1327 | | | | | | 28533 |
| 3 | 1015 | | | 1700 | 0 | 49304 | 21468 | | 11319 | | | 51004 | |
| | 1010 | | | | | | | | | | | | 32843 |
| 4 | 1010 | | | | | | | 32241 | 18681 | 0 | 6576 | 32241 | |
| | 1005 | | | | | | | | | | | | 25434 |
| 5 | 1005 | | | | | | | | | 11409 | 23424 | 11409 | |
| | 1000 | | | | | | | | | | | | 23321 |
| Нийт | $м^3$-ээр | 64666 | | 70474 | | 49304 | | 32241 | | 11409 | | 228094 | 132742 |
| | тн | | 12742 | | 30000 | | 30000 | | 30000 | | 30000 | 228094 | 132742 |
| | $м^3$-ээр | 98305 | | 149674 | | 128505 | | 111440 | | 90608 | | 578532 | |

# ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Уурхай орчимд тоосжилт үүсэх

- ✓ Уурхайн карьер болон тээврийн гол замыг чийгшүүлэх, услан тоос дарах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд, усны машин 25 сая төгрөгөөр худалдан авсан.
- ✓ Авто машины тусгай зориулалттай зогсоолтой байх
- ✓ Төсөлд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслүүд / нийт 7 техник/ 2025 оны 10 сарын 31 -нд оношлогоонд оруулжээ.
- ✓ Эвдрэлд, доройлтолд ороогүй газруудад машин техникүүдийг явуулахгүй байх, замын тэмдэглэгээг байршуулж тогтмол нэг замаар тээвэрлэлт хийх
- ✓ Төслийн талбайг тойруулж зээр болон бусад амьтадад ээлтэй хашаа барих
- ✓ Хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан овоолго байгуулан хадгалах
- ✓ Шингэн бохирыг соруулдаг “ОО” суурилуулан шингэн бохир зайлуулах гэрээ байгуулан зайлуулсан. Мөн ажилчдын тав тухтай байдалд усан орох газар байгуулсан, засвар үйлчилгээний материалын зардлыг хавсаргав.
- ✓ Дорнод аймгийн Байгаль орчны газраас 2025 оны ус ашиглах дүгнэлтийг авсан.



***Зураг 4. Уурхайн карьер болон гол замыг чийгшүүлж буй байдал***




*Зураг 5. Машины зогсоол*



*Зураг 6. Замын тэмдэг тэмдэглэгээг байршуулсан, замын төлөвлөгдсөн байдал*




*Зураг 7. Уурхайн тусгай зөвшөөрлийн талбай тойруулан далан болон анхааруулах тэмдэг байршуулсан байдал*



*Зураг 8. Бохир соруулдаг ОО байгуулсан байдал*

# 发票

发票号:HL20251029
日期:2025.10.29

卖方: 二连浩特市鸿利矿业有限公司
地址:内蒙古自治区二连浩特市锡林区南环路南、诚信路西景典花园小区 F 座 010118 号
电话:13789479393

买方:SHIDET OD LLC
地址:DORNOGOWI AIMAG, URGUN SUM,BARGILT OWOO
电话: 88906446, 99148566

买卖双方经协商按下列货物明细成交:

Niit hudaldaj awsan yums:

| 序号 D/D | 商品名称 BARAANII NERS | 数量 TOO | 单价（元）UNE | 总价（元）NIIT UNE |
|---|---|---|---|---|
| 1 | 60*60 方钢 TUMUR | 13 | 73 | 949 |
| 2 | 40*60 方钢 TUMUR | 40 | 63 | 2520 |
| 3 | 40*40 方钢 TUMUR | 71 | 56 | 3976 |
| 4 | 3.5cm 厚蓝色耐力板 DEEWER | 60 | 80 | 4800 |
| 5 | 压条 BOOLT | 10 | 20 | 200 |
| 6 | 胶条 NAALT | 2 | 40 | 80 |
| 7 | 螺丝 HADAAS | 2 | 25 | 50 |
| 8 | 外墙板 GADNA PASAT | 80 | 47 | 3760 |
| 9 | 防盗门 BURGED HAALGA | 4 | 1650 | 6600 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10 | PVC 接头 | 15 | 6 | 90 |
| 11 | 内角 BULAN | 45 | 6 | 270 |
| 12 | 外角 GADAR BULAN | 70 | 8 | 560 |
| 13 | 外泡沫板 SAIDING | 8 | 280 | 2240 |
| 14 | 外泡沫板 SAIDING | 10 | 180 | 1800 |
| 15 | 电线 TSAHILGAAN UTAS | 1 | 2183 | 2183 |
| 16 | 塑钢门窗 HAALGA | 1 | 4188 | 4188 |
| 17 | 顶板 DEEWER | 51 | 140 | 7140 |
| 18 | 外墙板 DOTOR PASAT | 15 | 183.6 | 2754 |
| 19 | 地板革 HULDAAS | 1 | 2150 | 2150 |
| 20 | 11KW 逆变器 NARNII TOLI | 1 | 32700 | 32700 |
| 21 | 3KW 逆变器 NARNII TOLI | 1 | 5550 | 5550 |
| 22 | 1KW 储热式电暖气 PAAR | 5 | 2300 | 11500 |
| 23 | 160L 热水器 US HALAAGUUR | 1 | 1700 | 1700 |
| 24 | 马桶 SUULTUUR | 2 | 350 | 700 |
| 25 | 脸盆(台柱) TOSGUUR | 2 | 90 | 180 |
| 26 | 水龙头 HOOLOI | 2 | 45 | 90 |
| 27 | 脸盆下水管 HOOLOI | 2 | 8 | 16 |
| 28 | 奇爱热水管 HOOLOI | 1 | 260 | 260 |
| 29 | 水龙头 HOOLOI | 2 | 80 | 160 |
| 30 | 等径弯头 BULAN | 10 | 12 | 120 |
| 31 | 铝塑管球阀-双头 BULAN | 10 | 15 | 150 |
| 32 | PVC 管-快插 | 15 | 23 | 345 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 33 | PVC 弯头-快插 | 6 | 25 | 150 |
| 34 | PVC 三通-快插 | 6 | 30 | 180 |
| 35 | PVC 大小头-快插 | 6 | 28 | 168 |
| 36 | 地磅 PUU | 1 | 77800 | 77800 |
| NIIT UNE | | | 178079 | |

卖方收款信息：

户名： 二连浩特市鸿利矿业有限公司

地址:内蒙古自治区二连浩特市锡林区南环路南、诚信路西景典花园小区1座 010118 号

电话:1378947939

账号：05711301040006290

开户行名称：中国农业银行股份有限公司二连浩特迎宾支行

开户行地址：内蒙古二连浩特市前进路北 0560 号

开户行代码：ABOCCNBJ050

开户行行号：103201171135

*Зураг 9. Засвар үйлчилгээний материалын зардлыг хавсаргав.*

**ДОРНОГОВЬ АЙМАГ**
**БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: (976) 7052 2663, факс: (02-522) 4-27-26
Цахим шуудан: Dgaboajg@do.mne.gov.mn
Цахим хаяг: www.do.mne.gov.mn

2025.10.29 № 581

танай_____________-ны №______________-т

“ШИДЭТ-ОД” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Я.ЭНХЧУЛУУН ТАНАА

Танай 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-2/20 тоот албан бичгээр ирүүлсэн 2025 оны Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, Хайгуулын ажлын төлөвлөгөөг үндэслэн 2025 оны ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүллээ.

Хавсралт .....хуудастай.

Хувийг: Аймгийн Татварын хэлтэс, Өргөн сумын Засаг даргын тамгын газарт

ДАРГА Н.ОТГОНБАЯР

4425030648

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
2025 ОНЫ УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 10 дугаар сарын 29-ны өдөр Дугаар 74 Сайншанд хот

1.Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:
“Шидэт-од”ХХК, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, 43-р байр, утас: 99112010, Улсын бүртгэлийн дугаар 9011364033, регистрийн дугаар 2884259

2. Төслийн нэр, байршил:
Өргөн сумын нутагт орших “Баргилт овоо” нэртэй 20,29 га талбайд хайлуур жоншны ордыг ашиглах ажил

3. Төсөл хэрэгжүүлэгч: “Шидэт-од” ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /Х,У/: MV-009631

| Х | У |
|---|---|
| 110⁰ 43’ 54.94” | 44⁰ 41΄ 50.56˝ |
| 110⁰ 43’ 31.94” | 44⁰ 41΄ 50.56˝ |
| 110⁰ 43’ 31.94” | 44⁰ 42΄ 03.55˝ |
| 110⁰ 43’ 54.94” | 44⁰ 42΄ 03.55˝ |

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:
Хайлуур жоншны ордыг ашиглах

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:
Уурхай нь хоногт 1 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна. Жилд 46 хүний бүрэлдэхүүнтэй 122 хоног ажиллана. Олборлолтын ажилд Hyundai Robex 290LC7 маркын экскаватор, Хятад улсад үйлдвэрлэсэн XCG-220L7A маркын утгуурт ачигч машин, Автосамсовал Howo, Өрмийн машин KY-125, Бульдозер Shantui SD23, түлш цэнэглэгч машин ашиглана. /2025 оны Уулын ажлын төлөвлөгөө-6, 15 хуудас/

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:
2025 онд нийт 12,74 мян.тн хүдэр олборлоно.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:
Тус сумын төвд өрөмдлөг гүний худаг байдаг ба усны чанар, ундарга сайтай тул энэ районы ахуй хэрэгцээний усны гол эх үүсвэр болдог.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/:

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:
Хаягдал бохир усыг хөрсөнд шингээн зайлуулдаг.

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл: БОНБНҮ-г 2025 онд “Монслов” ХХК-р хийлгэсэн.

14. Онцгой нөхцөл:

15. Холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандарт, баримт бичгийн дагуу усны зарцуулалтыг тооцох

Байгаль орчны сайдын 2015 оны А/301 дугаар тушаалаар баталсан “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд зарцуулах усны түр норм”-ын дагуу тооцоход

46хүн х 20л/хон х 122хон=112,2м$^3$/ ажиллах нийт хугацаанд-унд ахуйн усны хэрэгцээ

18000,0м$^2$ х 2л/м$^2$ х 1удаа/хон х 122 хон =4392,0м$^3$ зам талбайн тоосжилт дарахад ашиглах ус

200ш х 45л х 84 удаа= 756,0м$^3$ – ногоон байгууламжийн усалгаа

Нийт: 112,2м$^3$+4392,0м$^3$+756,0м$^3$ = 5260,2м$^3$ жилд ашиглана.

16. Холбогдох хууль, тогтоол шийдвэрийн дагуу оногдуулах усны нөөцийн төлбөрийн хэмжээ:

Замын талбайн тоосжилт дарахад ашиглах 4392,0м$^3$, ногоон байгууламжийн усалгаанд ашиглах 756,0м$^3$, ашиг олох зориулалтаар ашиглах 112,2м$^3$ газрын доорх усны төлбөрийн хэмжээг “Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2011 оны 302 дугаар тогтоолоор Галба-Өөш-Долоодын говийн сав газарт тогтоосон газрын доорхи усны экологи эдийн засгийн суурь үнэлгээ, Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолоор тогтоосон ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1-р хавсралтын 3,9-д заасан усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг үндэслэн тогтоож, хуулийн 23.6.5-д заасны ашигласан усны төлбөрийг аймгийн Төрийн сан 060000-944 дансанд төвлөрүүлж хувийг ирүүлэх

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 326, 327 дугаар тогтоолыг үндэслэн ус ашигласны төлбөрийг тооцвол:

1м$^3$ усны нөөц ашигласны төлбөр: 3996төг/м$^3$ х 0.20 х 0.25=199.8төг/м$^3$ байна.

- “Галба-Өөш-Долоодын говийн сав газарт”-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи-эдийн засгийн суурь үнэлгээ 3996 төг/м$^3$ байна.
- 20 хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 7а-д заасан хувь хэмжээ.
- 0.25- ашиглах усны ашиглалтын зориулалтын итгэлцүүр
- 2440,0м$^3$ жилд – зам талбайн тоосжилт дарах

4392,0 м$^3$ х 199,8= 877521,6 төг /найман зуун далан долоон мянга таван зуун хорин нэгэн төгрөг зургаан мөнгө/

1м$^3$ усны нөөц ашигласны төлбөр: 3996төг/м$^3$ х 10 х 0.25=99.9 төг/м$^3$ байна.

- 3996төг/м$^3$- “Галба-Өөш Долоодын говийн сав газар”-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
- 10 хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 9-д заасан хувь хэмжээ.
- 0.18- Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу Ногоон байгууламжийн зориулалтаар газрын доорхи усыг ашиглахад тооцох ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр

756,0 м$^3$ х 72,0= 54432,0 төг /нэг зуун хорин мянга есөн зуун жаран төгрөг/

1м$^3$ усны нөөц ашигласны төлбөр: 3996төг/м$^3$ х 0.15 х 0.16=95.9 төг/м$^3$ байна.

- 3996төг/м$^3$- “Галба-Өөш Долоодын говийн сав газар”-т газрын доорх ус ашигласан нөхцөлд тооцох экологи, эдийн засгийн суурь үнэлгээ
- 15хувь -Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын дагуу батлагдсан усны нөөц ашигласны төлбөрийн 4-д заасан хувь хэмжээ.

- 0.16- Засгийн газрын 2013 оны 327 дугаар тогтоолын дагуу ашиг олох зориулалтаар ашиглах газрын доорхи усыг ашиглахад тооцох ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр

112,2м$^3$/жил x 95,9 төг/м$^3$=10759,9 төг /арван зургаан мянга есөн зуун далан таван төгрөг/

Нийт: 877521,6 төг + 54432,0 төг + 10759,9 төг = 942713,5 төг /есөн зуун дөчин хоёр мянга долоон зуун арван гурван төгрөг таван мөнгө /

17. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх, эргүүлж ашиглах даалгавар:

18. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:
- Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Өргөн сумын Засаг даргын захирамжаар ус ашиглах зөвшөөрөл авч гэрээ байгуулах /"Усны тухай" хуулийн 28.6-р зүйл/
- Усны шинжилгээг хийлгэж дүнг ирүүлэх
- Хаягдал усны цэг тогтоолгох, дүгнэлт гаргуулан зөвшөөрөл авч гэрээ байгуулах
- Тоолууржуулан баталгаажсан тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож байх /Усны тухай хуулийн 30.1.4-д усны эх үүсвэрийг /БОНХС-ын 2013 оны А-156 тоот тушаалаар батлагдсан "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам"/
- "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэм"-ийг мөрдөн ажиллах /Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаал/
- "Аж ахуйн нэгжийн экологийн паспорт" хөтлөх /Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйл, Стандартчилал хэмжилзүйн хэлтэсээс авах/
- Зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг 50 хүртэл хувиар өсгөн тооцож төлөхөөр заасныг анхаарч ажиллах /Усны тухай хуулийн 31.2-р зүйл/
- Ус ашиглах зөвшөөрлийн хураамжийг Өргөн сумын Төрийн сан банкны дансанд тушааж хуулбар хувийг ирүүлэх /Монгол Улсын "Улсын тэмдэгтийн хураамжын тухай" хуулийн 21.1, 20-р зүйл, Дорноговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2011 оны 51-р тогтоол/
- Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс болох 50 000 төгрөгийг Байгаль орчны газрын Төрийн сан банкны 100 060013001 дансанд тушаах /Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А-376 тоот тушаал/

Зөвлөмжид заасан ажлын тайлан, Ус ашиглалтын мэдээ тайланг 12-р сарын 05-нд багтаан аймгийн Байгаль орчны газарт ирүүлэх

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН: Ш. АМГАЛАНСАЙХАН

БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН ДАРГА: Н. ОТГОНБАЯР

ДОРНОГОВЬ АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР
2025 ОНЫ УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

2025 оны 10 дугаар сарын 29-ны өдөр Дугаар 74 Сайншанд хот

1.Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, хаяг, утас факс, улсын бүртгэлийн дугаар:
"Шидэт-од"ХХК, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Энгельсийн гудамж, 43-р байр, утас: 99112010, Улсын бүртгэлийн дугаар 9011364033, регистрийн дугаар 2884259

2. Төслийн нэр, байршил:
Өргөн сумын нутагт орших "Баргилт овоо" нэртэй 20,29 га талбайд хайлуур жоншны ордыг ашиглах ажил

3. Төсөл хэрэгжүүлэгч: "Шидэт-од" ХХК

4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /Х,У/: MV-009631

| X | У |
|---|---|
| 110⁰ 43' 54.94" | 44⁰ 41' 50.56" |
| 110⁰ 43' 31.94" | 44⁰ 41' 50.56" |
| 110⁰ 43' 31.94" | 44⁰ 42' 03.55" |
| 110⁰ 43' 54.94" | 44⁰ 42' 03.55" |

5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл зориулалт:
Хайлуур жоншны ордыг ашиглах

6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/:
Уурхай нь хоногт 1 ээлжээр ажиллах ба ээлжийн үргэлжлэх хугацаа 8 цаг байна. Жилд 46 хүний бүрэлдэхүүнтэй 122 хоног ажиллана. Олборлолтын ажилд Hyundai Robex 290LC7 маркын экскаватор, Хятад улсад үйлдвэрлэсэн XCG-220L7A маркын утгуурт ачигч машин, Автосамсовал Howo, Өрмийн машин KY-125, Бульдозер Shantui SD23, түлш цэнэглэгч машин ашиглана. /2025 оны Уулын ажлын төлөвлөгөө-6, 15 хуудас/

7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ:
2025 онд нийт 12,74 мян.тн хүдэр олборлоно.

8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах хэмжээ /шоо.метрээр/:
Тус сумын төвд өрөмдлөг гүний худаг байдаг ба усны чанар, ундарга сайтай тул энэ районы ахуй хэрэгцээний усны гол эх үүсвэр болдог.

9. Усны барилга байгууламжууд /нэр, хүчин чадал, барилга, байгууламжийн хэмжээ хийц/:

10. Худаг, өргөлтийн станцууд, усны тоолуур /насосны хүчин чадал, марк/:

11. Дамжуулах байгууламж /шугам сүлжээний урт, диаметр/:

12. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин:
Хаягдал бохир усыг хөрсөнд шингээн зайлуулдаг.

13. Байгаль орчны үнэлгээ, нөхцөл: БОНБНҮ-г 2025 онд "Монслов" ХХК-р хийлгэсэн.

14. Онцгой нөхцөл:

## ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ЗАРДАЛ

Техникийн болон биологийн нөхөн сэргээлт эхний жилд төлөвлөөгүй болно.

## ДӨРӨВ. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Өргөн сумтай хамтран тус сумын 1-р багийн нутагт орших Сүмийн булгийн орчныг тохижуулах, мод тарих ажлыг хийж гүйцэтгэв. Ажлын төсөвт 12500сая төг зарцуулсан. Үүнд хашаалах, мод тарих зардал багтсан



*Зураг 10. Мод тарин хашаалсан байдал*

## ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг цех хаагдах үед хаалтын зардалд тооцохоор төлөвлөсөн болно.

## ЗУРГАА. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Баргилт овоо” ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна

## ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛ, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- ✓ Дорноговь аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбооны дэргэдэх ХАБЭА-ын сургалтын төвтэй гэрээ байгуулан Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг 2025 оны 10 сарын 27-ны өдөр зохион байгуулж оролцоог хангуулан

ажиллав. Сургалтанд нийт 7 хүн оролцсон. Сургалтын хөтөлбөр, баримт, зургийг доор үзүүлэв.

- ✓ Ажиллагсдыг улиралд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулсан
- ✓ Ажиллагсдыг тоосноос хамгаалах хошуувч, хувцас хэрэгслээр хангасан

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ
ДЭРГЭДЭХ ХАБЭА-Н СУРГАЛТЫН ТӨВИЙН
ЗАХИРАЛ .......................... Г.АЛТАНГАДАС

**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН НИЙТ АЖИЛТНЫ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**Сургалтын зорилго:** *Ажил хөдөлмөр эрхэлж буй нийт ажилтан, иргэнд аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс амь нас, эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н хууль эрх зүйн ойлголтыг өгөхөд энэхүү сургалтын зорилго оршино.*

**Зохион байгуулах байгууллага:** Аймгийн ҮЭ-ийн холбооны дэргэдэх ХАБЭА-н сургалтын төв

**Сургалтын хугацаа:** 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

| № | Цаг | Сэдэв | Хичээл заах багш |
|---|---|---|---|
| **2025 оны 10 дугаар сарын 27 – ны өдөр Даваа гараг** | | | |
| | 08⁴⁵ – 09⁰⁰ | Сургалтын бүртгэл | Зохион байгуулагчид |
| 1 | 09⁰⁰ – 11⁰⁰ | • ХАБЭА-н үндсэн ойлголт<br>• ХАБЭА-н тухай хууль тогтоомж<br>• Үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюултай хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт<br>• Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлийн төрөл, мэргэжлээс шалтгаалсан өвчин | **Д.Хатантуул**<br>ХАБЭА-н Олон улсын багш арга зүйч |
| | 11⁰⁰ – 11²⁰ | **ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА** | |
| | 11²⁰ – 12⁰⁰ | • Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, зохистой хэрэглээ<br>• Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг таньж илрүүлэх, мэдээлэх, бууруулж арилгахад ажилтан бүрийн үүрэг, оролцоо | |
| 2 | 12⁰⁰ – 13⁰⁰ | **ҮДИЙН ЗАВСАРЛАГА** | Менежер |
| 3 | 13⁰⁰ – 16⁰⁰ | • Ажилд эхлүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ хийх арга<br>• Онцгой байдалд хэрэгжүүлэх арга хэмжээ, гамшгийн бэлэн байдал<br>• Осолд өртөгсдөд үзүүлэх анхны тусламж | **Д.Хатантуул**<br>ХАБЭА-н Олон улсын багш арга зүйч |
| 4 | 16⁰⁰ – 16²⁰ | **ЦАЙНЫ ЗАВСАРЛАГА** | **Д.Оюундалай**<br>ХАБЭА-н сургалтын төвийн менежер |
| 5 | 16²⁰ – 18⁰⁰ | • Ажилтны зан үйлтэй холбоотой өвчлөл, түүний урьдчилан сэргийлэлт | |
| 6 | 18⁰⁰ – 18²⁰ | Сертификат гардуулах | Багш, менежер |

---oOo---

*Зураг 11. ХАБЭА-ын сургалтын сургалтын хөтөлбөр*



*Зураг 12. ХАБАЭ сургалтын үед*



*Зураг 13. Сургалтанд оролцогчид*



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, СУРГАЛТАД ОРОЛЦОГСОДЫН БҮРТГЭЛ

2025 оны 10 сарын 27-нд

Байгууллагын нэр "Шидэт Од ХХК"

| № | Овог нэр /бүтнээр бичнэ/ | Албан тушаал | Харилцах утас | Сертификат олгосон эсэх | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1 | [illegible] | Менежер | 99148566. | ✓ | |
| 2 | [illegible] | Захирал. | 88906446. | ✓ | |
| 3 | [illegible] | Кемп Менежер. | 99108940. | ✓ | |
| 4 | [illegible] | Домп оператор. | 99471808. | ✓ | |
| 5 | [illegible] | Ковш оператор. | 86921746. | ✓ | |
| 6 | [illegible] | Оператор. | 88584053. | ✓ | |
| 7 | [illegible] | Оператор. | | ✓ | |
| 8 | | | | | |
| 9 | | | | | |
| 10 | | | | | |
| 11 | | | | | |
| 12 | | | | | |
| 13 | | | | | |
| 14 | | | | | |
| 15 | | | | | |

*Зураг 14. ХАБЭА-н хуулийн зөвлөгөө өгөх, сургалтанд оролцогчдын бүртгэл*









*Зураг 15. Уурхайн байгууламжид ХАБЭА болон галын аюулгүй ажиллагааны самбар байршуулсан байдал*



*Зураг 16. Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл*




*Зураг 17. Хувцас хэрэгслээр хангагдсан байдал, төлбөрийн баримтын хамт*

# НАЙМ. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- ✓ Оффис, байгууллага дотор хог хаягдлыг ялган хаях хогийн савыг байршуулах
- ✓ Хог хаягдлыг ялгах, зайлуулах төвлөрсөн цэг байгуулах
- ✓ Хог хаягдлын гэрээг Дорноговь аймгийн Өргөн сумын засаг даргатай байгуулан хогийн цэгт нийлүүлж байх
- ✓ Уурхайн талбайг хог хаягдлаар бохирдох нөхцөл үүсэхэд тухай бүр цэвэрлэж байх
- ✓ Аюултай хог хаягдлыг кодлон ялгаж бүртгэлжүүлэх
- ✓ Аюултай хог хаягдлын тусгай саванд хадгалах
- ✓ Нийлүүлэгч талд буцаан өгөх арга хэмжээг хэрэгжүүлэх
- ✓ 2024-2025 онд ахуйн шингэн бохирыг цэвэрлэх байгууламж тавих




***Зураг 18. Хог хаягдлын цэг***

БАТЛАВ. ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ӨРГӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Т.БАТ-АМГАЛАН

**ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ**
**№09**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хуулийн 8.4, 9.2, 20.1,20.2, Сумын ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 10/07 дугаар тогтоолыг үндэслэв.

1.2 Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах түүнээс урьдчилан сэргийлэх ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, дахин боловсруулж эргүүлэн ашиглах, тээвэрлэх, булах болон орчны ариун цэврийг тогтмол цэвэр байлгах, цэвэр эрүүл орчинд ажиллаж амьдрах орчныг бий болгоход оршино.

**Хоёр. Гэрээ байгуулагч талууд**

2.1 Нэг талаас **Дорноговь** аймгийн **Өргөн** сумын ЗДТГ-ыг төлөөлж Байгаль орчны бодлогын мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч **Э.Баярсүрэн** нөгөө талаас **2884259** дугаар регистрийн **“Шидэт-Од” ХХК-** ийн **захирал Г.Чулуунхүлэг** нар харилцан тохиролцож **2025** оны **01 дүгээр** сарын **10**-ны өдрөөс **2025** оны **12** дугаар сарын **31**-нийг хүртэл хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

**Гурав. Сумын ЗДТГ-ын эрх үүрэг**

3.1 Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хог хаягдлын хуулийн дагуу хяналт тавьж ажиллана.

3.2 Аж ахуй нэгж байгууллагын барилгын хог хаягдал гаргасан хураамжийг Сумын ИТХ-ын 2023 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн 10/07 тоот тогтоолоор Ахуйн хэрэглээний хог хаягдал уурхайн 1 сарын 50,000 төгрөгөөр тооцно.

**Дөрөв.”Шидэт-Од ” ХХК-ийн хүлээх эрх үүрэг**

4.1.Өөрийн байгууллагын үйл ажиллагаанаас гарсан ахуйн хог хаягдал, Үйлдвэрлэлийн хог хаягдлыг стандартын шаардлага хангасан зориулалтын саванд ангилан хадгалж байх.

4.2 Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны хураамжийг сумын төрийн сан банкны **100060700947** тоот дансанд бүрэн төлөх

4.3 Аж ахуй нэгж байгууллага нь хог хаягдлыг 7 хоног бүрийн 4 дэх өдөр сумын Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж ачуулах.

4.4 Төлөх нийт төлбөр: 12 сар*50,000 /1 сарын төлбөр/=600,000 /Зургаан мянган төгрөг/.

**Нийт төлбөр:** 600,000 / зургаан зуун мянга төгрөг/

4.5 Ахуйн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэж тээвэрлэх, хог хаягдлын талаарх дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж зориулалтын цэгт хаяж байхад анхаарах.

4.6 Үйлдвэр үйлчилгээний явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ, бусад мэдээллийг Сумын ЗДТГ-т мэдээлж байх.

4.7 Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтнуудад эзэмшүүлж, сургалт сурталчилгаа явуулах аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах.
4.8 Аюултай хог хаягдлыг зориулалтын бус газар хаяхыг хатуу хориглоно.
4.9 Барилгын хог хаягдлыг зориулалтын бус газар хаяхыг хатуу хориглоно.

**Тав. Гэрээний хариуцлага**

5.1 Аж ахуйн нэгж байгууллага нь хог хаягдал гаргасны төлбөрөө төлөөгүй болон ил задгай шатаасан, зориулалтын бус газар хог хаяг хаясан нөхцөлд өр авлагыг барагдуулах ба учруулсан хохиролыг арилгуулах шаардлагатай тохиолдолд холбогдох дээд шатны байгууллагад хандан хог хаягдлын тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

5.2 Аж ахуй нэгж байгууллага нь энэхүү гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл хоёр талын хамтарсан төлөөлөгч тухай бүр шийдвэрлэнэ.

| | |
|---|---|
| **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:** | |
| ӨРГӨН СУМЫН ЗАСАГ | “ШИДЭТ-ОД ХХК-ийн |
| ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН | ЗАХИРАЛ |
| БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН | /Г.ЧУЛУУНХҮЛЭГ/ |
| /Э.БАЯРСҮРЭН/ | Утас:99992311 |
| Утас: 88049952 | |

ШИДЭТ—ОД ХХК
ТТН40.3.2984259

БАТЛАВ
“ШИДЭТ-ОД” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ Я.ЭНХЧУЛУУН

БАТЛАВ
“ЧАНДМАНЬ-ИЛЧ” ХХК-НИЙ
ЗАХИРАЛ Д.ТӨМӨРБААТАР

ЧАНДМАНЬ-ИЛЧ ХХК 0624120019 ДОРНОГОВЬ АЙМАГ

## БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ /ДОРНОГОВЬ САЙНШАНД /

2025 он 10-р сарын 29 № БО-2025/49 Сайншанд хот

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Нэг талаас “Шидэт орд” ХХК (цаашид “Захиалагч” гэх)-ийг төлөөлж менежер Адъяа овогтой Мөнхжаргал

Нөгөө талаас "Чандмань-Илч" ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ийг төлөөлж Эдийн засагч Г.Батхишиг нар (цаашид хамтад нь “талууд” гэх) харилцан тохиролцож, Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 болон холбогдох бусад хууль эрх зүйн актыг удирдлага болгон энэхүү гэрээг байгуулав.

1.2.Гүйцэтгэгч нь захиалагчийн Дорноговь аймгийн Өргөн сумын нутагт Шидэт од ХХКийн жоншны уурхайн байршилтай ажилчдын суурингийн ахуйн (цаашид “Байгууламжууд” гэх) бохир усыг гэрээний хугацаанд татан зайлуулах (цаашид “Ажил” гэх) ажлыг хийж гүйцэтгэнэ.

### Хоёр. Гэрээний хөлс

2.1.Ажлын хөлс нь энэхүү гэрээний үнийн дүн буюу Дорноговь аймгийн Өргөн суман дахь байгууламжид нэг удаа 4 тонн бохир ус татан зайлуулахад тухайн оны мөрдөж буй тарифаар тооцон төлбөрийг төлнө. /44,000₮+1км2200/ /1 рейс 44,000+14км*2200+НӨАТ буюу нэг удаагийн соролтын нийт төлбөр 79,200.0 төгрөг/ -өөр тооцно.

2.2.Захиалагч гүйцэтгэгчийн ирүүсэн нэхэмжлэх, талуудын баталгаажуулсан энэхүү гэрээний хавсралт Маягт1-ийг үндэслэн гэрээний хөлсийг олгоно.

### Гурав. Гэрээний хугацаа

3.1.Гэрээний ерөнхий хугацаа нь 1 жил байна.

3.2.Гэрээний эхлэх хугацаа: 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр.

3.3.Гэрээний дуусах хугацаа: 2026 оны 10-р сарын 31-ний өдөр.

3.4.Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж захиалагч тал 1 хувийг, гүйцэтгэгч тал 1 хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

3.5.Захиалагч болон гүйцэтгэгч нь гэрээний хугацааг сунгах эсэх асуудлыг энэхүү гэрээний 3.3.-т заасан хугацаа дуусахаас 1 сарын өмнө харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Гэрээний хугацаа дуусахад аль нэг талаас гэрээг цуцлах буюу дуусгавар болгох санал ирээгүй тохиолдолд цаашид дахин нэг жилээр ижил нөхцөлөөр сунгагдсанд тооцно.

3.6.Захиалагч болон гүйцэтгэгч нь хүндэтгэн үзэх үндэслэлтэй нөхцөлд гэрээнээс хэдийд ч татгалзаж болох бөгөөд энэ тухайгаа нөгөө талдаа 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ. Талууд өөрөөр харилцан тохиролцоогүй бол ажил гүйцэтгэх гэрээ нь бичгээр мэдэгдэл өгснөөс хойш 30 хоногийн дараа дуусгавар болно.

Дөрөв. Захиалагчийн эрх, үүрэг

4.1.Захиалагчийг төлөөлж тухайн байгууламжын ээлжийн инженер нь бохир ус татан зайлуулах ажил гүйцэтгүүлэх захиалга өгнө.

4.2.Гүйцэтгэгч талыг ажил үүргээ гүйцэтгэх бололцоогоор хангана.

4.3.Гүйцэтгэгчийн үйл ажиллагаанд саад болохгүйгээр ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гүйцэтгэлийг чанартай, зохих ёсоор гүйцэтгэхийг шаардах, шаардлагатай бол ажлын гүйцэтгэлийг залруулахыг шаардах, гүйцэтгэж буй ажил нь эрүүл ахуйн болон чанарын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт тавьж шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулах эрхтэй.

4.4.Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол илэрвэл доголдлыг арилгуулах эрхтэй.

4.5.Талуудын хянаж, баталгаажуулсан гэрээний хавсралт Маягт1 баримт, нэхэмжлэлийг үндэслэн ажлын 5 өдөрт төлбөрийг гүйцэтгэгч талын дансанд шилжүүлнэ.

Тав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

5.1.Ажлыг байгаль орчин бохирдуулахгүй, хүн, мал, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөхгүй, эдгээртэй холбоотой хууль, дүрэм, журмуудыг зөрчихгүйгээр чанар, стандарт шаардлагын дагуу тогтоосон хугацаанд биечлэн татан зайлуулах үүрэгтэй.

5.2.Захиалагчийн ажлын байранд ажиллаж байхдаа хөдөлмөрийн дотоод журам, дүрэм, зааврыг ажилтнуудын нэгэн адил чанд баримтлан ажиллах үүрэгтэй.

5.3.Ажил гүйцэтгэхтэй холбоотой гарсан аливаа зөрчил маргаантай асуудлыг (байгаль орчин бохирдуулсан, хүн, мал, амьтны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн гэх мэт) бүрэн хариуцана.

5.4.Таван тонн-ын багтаамжтай 65-28 ДГА Улсын бүртгэлийн дугаартай тээврийн хэрэгслээр ажил гүйцэтгэх ба техник хэрэгсэл, машин механизмын бүрэн, бүтэн байдлыг бүрэн хариуцна.

5.5.Ажил гүйцэтгэх гэрээг дуусгавар болгох үед гүйцэтгэгч нь захиалагчаас ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байсан тухай болон түүний үргэлжилсэн хугацааны талаар бичгээр тодорхойлолт гаргаж өгөхийг шаардах эрхтэй.

5.6.Ажил гүйцэтгэх үед аюулгүй Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, холбогдох дүрэм, журмыг чанд баримтлан аюулгүй байдлыг бүрэн хариуцана.

5.7.Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, ажил гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нөхцөл байдал бий болсон бол захиалагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

5.8.Ажлын үр дүнгийн доголдлыг арилгахад шаардагдах зардлыг (ажлын хөлс, материалын зардал, замын хураамж болон тээврийн хөлс г.м) хариуцах үүрэгтэй.

5.9.Ажлыг өөрийн зардлаар гүйцэтгэж гэрээний хавсралт Маягт 1-ийн дагуу баримт үйлдэж, баталгаажуулан нэхэмжлэхийн хамт захиалагчид хүргэнэ.

5.10.Гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдолд өөрчлөлт оруулах болсон үндэслэл, саналаа захиалагчид албан бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

5.11.Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажил гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд захиалагч талд албан бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

Зургаа. Нууцлал хадгалах

6.1.Гүйцэтгэгч нь гэрээнд заасан үүргээ биелүүлэх явцад олж мэдсэн бүхий л нууц мэдээллийг гуравдагч этгээдэд аливаа хэлбэрээр мэдээлэх, дамжуулах, тараахыг хатуу хориглоно. Тараасан бол холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээнэ.

Долоо. Талуудын хариуцлага

7.1.Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үнийн дүнгээр хоног тутамд 0,05 хувийн алданги төлнө.

7.2.Хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас аль нэг талд хохирол учирсан тохиолдолд уг хохирлыг гэм буруутай тал нь бүрэн хариуцаж арилгах үүрэгтэй.

7.3.Гүйцэтгэсэн ажлын үр дүн доголдолтой бол гүйцэтгэгчийн зардлаар уг доголдлыг арилгуулна.

7.4.Захиалагч ажлын үр дүнг хүлээн авч, хөлсийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,05 хувийн алданги тооцож, гүйцэтгэгчид төлнө.

Найм. Гэрээ цуцлах үндэслэл

8.1.Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй дараах тохиолдолд захиалагч гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

8.1.1.Захиалагчийн итгэлийг алдсан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан.

8.1.2.Гүйцэтгэгч гэрээнд заасан үүргээ өөрөө биечлэн гүйцэтгээгүй буюу бусдад дур мэдэн шилжүүлсэн;

8.1.3.Гүйцэтгэгч гэрээнд заасан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа өөрийн буруугаас захиалагчид эд хөрөнгийн ноцтой хохирол учруулсан;

8.1.4.Гүйцэтгэгч ажил үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн мэдээ, мэдээллийг задруулсан, задруулахаар завдсан;

8.1.5.Гүйцэтгэгч удаа дараа захиалагчийн шаардлагын дагуу ажлын доголдлыг сануулсаар байтал санаатайгаар засварлаж, арилгаагүй;

8.1.6.Хуульд заасан бусад үндэслэл.

8.2.Захиалагч гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн үйл ажиллагаа явуулаагүй, гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу гэрээнд харш үйл ажиллагаа явуулсны улмаас гэрээг цуцалсан бол гүйцэтгэгч ажлын хөлс шаардах эрхээ алдана.

8.3.Гүйцэтгэгч ажлын хөлсийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг урьдчилан авсан үед 8.1-д заасан нөхцөлөөр гэрээ цуцлагдсан бол урьд олгосон ажлыг хөлсийг буцаан төлүүлнэ.

8.4.Энэ гэрээний 8.1.-д зааснаас өөр үндэслэлээр гэрээ цуцлах тохиолдолд талууд нөгөө талдаа гэрээний хугацаа дуусахаас нэг сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэнэ.

8.5.Энэ гэрээний 8.4-т заасан үндэслэлээр гэрээ цуцлах санал гаргасан тал түүнээс үүдэн гарах эрх зүйн үр дагаварыг бүрэн хариуцна.

8.6.Захиалагчийн удирдлага өөрчлөгдсөн нь гэрээ цуцлах үндэслэл болохгүй.

Ес. Гэрээ хүчин төгөлдөр болох

9.1.Гэрээнд талууд гарын үсэг зурж, өөрсдийн тамга (тэмдэг)-аар албажуулснаар хүчин төгөлдөр болно.

Арав. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

10.1.Гэрээний хугацаа, нөхцөлийн талаар өөрчлөлт оруулахаар бол саналаа бичгээр гаргаж хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

10.2.Гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр үйлдэж, талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

10.3.Талууд гэрээний үүрэгтэй холбогдон гарсан аливаа маргааныг харилцан зөвшилцөж шийдвэрлэх ба зөвшилцөлд хүрэхгүй тохиолдолд асуудлаа Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: | ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ: |
|---|---|
| МЕНЕЖЕР: А.МӨНХЖАРГАЛ | ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Ө.ДАВААЖАВ |
| | ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ Л.НАРАНХҮҮ |
| | ЭДИЙН ЗАСАГЧ Г.БАТХИШИГ |
| Хаяг: Улаанбаатар хот, БЗД, 2-р хороо, Дарь эх 12-392 тоот | Хаяг: Дорноговь аймаг Сайншанд сум 2 баг Эрх чөлөөний гудамж |
| Утас/Факс: 99148566, 99112010 | Утас, Факс: 70522405, 96603557 |
| | Дансны дугаар: “ХААН БАНК” 5360001473 /төгрөг/ |

ХААН БАНК

Огноо/Date: **2025-10-28 15:00:46**

**Шилжүүлгийн мэдээлэл**/Transaction information
Журналын /Journal No: **23942810**
Гүйлгээний дугаар /Poid: **0**

Системийн огноо/System Date: **2025-10-28**

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Дт** | IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card number<br>**5608088833** | Нэр/Name<br>**НОЁН АДЪЯА МӨНХЖАРГАЛ** | Дүн/Amount<br>**218,000.00 MNT** | Ханш/Rate<br>**1.00** |
| **Кт** | Банкны дугаар/Branch No<br>**MOFUMNUB**<br>IBAN/Дансны/Картын дугаар<br>IBAN/Account/Card Number<br>**100060013015** | Банкны нэр/Bank Name<br>**ТӨРИЙН САН**<br>Нэр/Name<br>**До.УЦУОШАлба** | **218,000.00 MNT** | **1.00** |

Гүйлгээний утга/Transaction description:
**шидэт од ххк**

**Харилцагч танд баярлалаа.**/Thank you to our customers

Овог, нэр/Fullname: Рэнцэнбат овогтой Мөнхтуяа / Munkhtuya Rentsenbat
Албан тушаал/Position: Гүйцэтгэх захирал / Chief executive officer
Баталгаажуулах код/Verification code:
**RHE3ECT5NGUCK5PU**
Уг баримт бичиг нь Монгол Улсын "Цахим гарын үсгийн тухай" хуулийн 8.1 дугаар заалтын дагуу тамгыг орлох чадамжтай тоон гарын үсгээр баталгаажсан болно.
*This document is verified by a digital signature that can replace an official stamp under the 8.1st clause of Mongolian Law on Digital Signatures.*
Та https://verify.khanbank.com/ вебсайт руу хандан дээрх 16 орон бүхий кодыг оруулснаар мэдээллийг шалгах боломжтой. Мөн уг холбоосоор дамжин цахим тоон гарын үсгийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.
*You can verify this document by going to https://verify.khanbank.com/ and entering the 16-digit verification code provided. You can also find more information about digital signature on this page.*

**Санамж**: Бага дүнтэй (Таван сая төгрөг хүртэлх дүнтэй) гүйлгээ тухайн данс руу шууд шилжих бөгөөд таван сая төгрөгөөс дээш дүнтэй үед хүлээн авагчийн нэр, данс зөрвөл таны данс руу буцан орно. Амжилттай гүйлгээний баримт таны бүртгэлтэй и-мэйл хаяг руу илгээгдэнэ. Ажлын өдрийн 16:00 цагаас хойш болон амралтын өдөр таарсан их дүнтэй (таван сая төгрөгөөс дээш дүнтэй) гүйлгээ дараагийн ажлын өдөр хийгдэхийг анхаарна уу

# ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5 өдрийн 347 тоот тушаалын хавсралт

## НЭХЭМЖЛЭХ №

Нэхэмжлэгч:
Байгууллагын нэр:ДО.УЦУОШТӨВ

Хаяг: Дорноговь аймгийн 6-р баг 8-817 тоот
РД:9025995
Утас, факс: 91294845
Э-Шуудан.......................................
Банкны нэр:Төрийн сан банк
Банкны дансны дугаар: IBAN610090100060013015

Төлөгч:
Байгууллагын нэр: ШИДЭТ ОД ХХК
Хаяг:
РД
Гэрээний №
Нэхэмжилсэн огноо: 2025.10.28
Төлбөр хийх хугацаа: 5 хоног

| № | Гүйлгээний утга | тоо хэмжээ | нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Агаар | 2 | 24,500 | 49,000 |
| 2 | Тоос | 2 | 20,000 | 40,000 |
| 3 | Хөрс | 1 | 68,500 | 68,500 |
| 4 | Ус | 1 | 60,500 | 60,500 |
| | | | | |
| | | | | |
| | | | Дүн | |
| | | | НӨАТ | |
| | | | Нийт дүн | 218,000 |

Мөнгөн дүн: /Хоёр зуун арван найман мянган / төгрөг

(Тамга) Дарга ......................../Ш.Амарбилэг/

Нягтлан бодогч................................/А.Мөнхсар /

Дорноговь аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв САНХҮҮ ТТ-8560 9025995

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үзүүлэлтүүд | Жилд /мян.төг/ |
|---|---|---|
| Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал | | |
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хөтөлбөр | 28100 |
| 2 | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2436 |
| 3 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 2470.0 |
| 4 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 218 |
| 5 | Олон нийтийн оролцоог хангах төлөвлөгөө | - |
| Нийт | | **30754** |
| Нөхөн сэргээлтийн зардал | | |
| 7 | Техник нөхөн сэргээлтийн зардал | - |
| 8 | Дүйцүүлэн хамгаалах зардал | 12500 |
| Нийт | | **43254** |

*Хүснэгт 6.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын тооцоо*

“Шидэт орд” ХХК нь 2025 онд Байгаль орчин менежментийн зардалд нийт 43.254 сая.төг зарцуулсан.